



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,
хамгаалах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 11 дахь заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16, 13.1.17 дахь заалт болон Улсын онцгой комиссын 2020 оны "Ой, хээрийн гал, түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тухайн аймаг, орон нутгийн цаг уурын нөхцөлөөр тогтоосон түймрийн аюулын зэрэглэлд үндэслэн ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтыг эрчимжүүлэх, сургалт сурталчилгаа явуулах; ойд зорчих иргэн, ойн болон байгаль хамгааллын сайн дурын нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулж баталгаа гаргуулан хяналт тавьж ажиллах; түймрийн аюулын үнэлгээ гурав болон түүнээс дээш зэрэглэлд хүрсэн тохиолдолд тухайн аймаг, сумын нутгийн хэмжээнд ойд явуулж буй ой аж ахуйн арга хэмжээ болон иргэдийн аялал зугаалга, амралт, сувиллын зорилгоор ой, хээрийн бүсэд зорчих үйл ажиллагааг хориглохыг бүх шатны Засаг дарга, Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Ой, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээлэл авах, түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий жижүүрийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулах, түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталж, шаардагдах төсвийг ойжуулалт, ой хамгааллын зардлаас санхүүжүүлж, үйл ажиллагаанд хяналт тавихыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

3. Түймрийн жижүүрийг ой, хээрийн түймрийн голомт, тархалтын зураг бусад шуурхай мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд ажлын бус цагаар болон амралтын өдрүүдэд сансрын хиймэл дагуулын түймрийн тархалтын зургийг шуурхай боловсруулж, www.icc.mn сайтад байршуулах болон мэдээлэл солилцох холбооны хэрэгслээр хангаж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (С.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

4. Хавар, намрын хуурайшилтын улиралд олон нийтийн телевиз, радио, цаг агаарын мэдээллийн хөтөлбөрөөр түймрийн аюулын хуурайшилтын зэргийг 7 хоног бүрээр тодорхойлж гал, түймрийн эрсдэл өндөртэй аймаг, сумдыг тогтмол мэдээлж байхыг Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (Г.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

010402

5. Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эргүүл шалгалтыг эрчимжүүлэх, түймэр унтраах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулах, зардлыг шийдвэрлэж ажиллах талаар Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад тодорхой үүрэг, даалгавар өгч, хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар (Э.Сансарбаяр)-т үүрэг болгосугай.

6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гарсан түймрийг шуурхай илрүүлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгө, байгалийн нөөц баялгийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг оновчтой зохион байгуулж, мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэхийг Ойн бодлого, зохицуулалтын газар—(Б.Оюунсанаа), Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар (П.Цогтсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

7. Түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутагт түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын техникийн болон мэргэжлийн бэлэн байдлыг хангуулах ажлыг эрх бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулах болон энэ тушаалд заасан арга хэмжээний хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд (Ц.Батбаяр), Ойн бодлого, зохицуулалтын газар (Б.Оюунсанаа) нарт тус тус даалгасугай.

САЙД  Н.ЦЭРЭНБАТ



Байгаль орчин, аялал жуулчлалын
сайдын 2020 оны 01 дугаар сарын 09-ны
өдрийн 11.62 дугаар тушаалын хавсралт

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВРЫН ДАГУУ ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ТАЛААР 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Улсын онцгой комиссын 2020 оны 01 дугаар албан даалгаврын заалт | Авах арга хэмжээ | хугацаа | Хэрэгжүүлэх газар, нэгж | Биелэлт |
|----|---|---|-----------------|---|---------|
| 1. | 1.1. Ой, хээрийн гал, түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулах | 1. 2020 онд 30,0 мянган га-аас доошгүй ойн талбайд арчилгаа, цэвэрлэгээ, 12,0 мянган га ойн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийнэ. 2. Улсын хилийн дагуух ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах 500 км-ээс доошгүй урт шороон зурваст арчилгаа хийх, өргөсгөх, шинээр байгуулах ажлыг Хил хамгаалах ерөнхий газар(ХХЕГ)-тай гэрээ байгуулж, хамтран хэрэгжүүлэх 3. Түймрийн эрсдэл өндөртэй Сэлэнгэ аймагт усан сан, цөөрөм байгуулах ажлыг эхлүүлнэ. | 2,3, 4-р улирал | - Байгаль орчин, аялал жуулчлалын яам(БОАЖЯ)-ны Ойн бодлого зохицуулалтын газар(ОБЗГ) - Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар - ХХЕГ, салбарууд | |
| 2. | 1.2. Ой, хээрийн гал, түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр иргэд, ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллагуудыг сургаж дадлагажуулах ажлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | 1. ОБЕГ болон түүний аймаг, орон нутгийн салбаруудтай хамтран түймрийн аюултай улиралд ой, хээрийн бүсэд ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 2. Монгол улс, ОХУ-ын хил зэргэлдээх бүс нутгуудын төрийн байгууллагуудын оролцоог хангасан түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хянах хамтарсан сургуулилт, дадлагыг Сэлэнгэ аймагт зохион байгуулна | 2,3, 4-р улирал | - БОАЖЯ-ны ОБЗГ, хэвлэл, мэдээллийн алба - Онцгой байдлын ерөнхий газар(ОБЕГ), - Гал түймэртэй тэмцэх газар | |
| 3. | 1.3. Ой, хээрийн гал, түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг баг, хороодод Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль | 1. Түймрийн аюултай улирлын хугацаанд Байгаль хамгаалах салбарын харьяа төрийн болон төрийн бус байгууллагуудад Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай | Жилийн турш | - БОАЖЯ - Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын | |

| | | |
|--|---|--|
| <p>орчныг хамгаалах тухай хуулиуд, Монгол улсын ерөнхийлөгчийн 2019 оны 59 дүгээр сарын 06-ны өдрийн 153 дугаар зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах</p> | <p>үүрэгжүүлсэн Сайдын тушаал гаргаж хэрэгжилтийг хангуулна.</p> <p>2. Ойн тухай хууль, тогтоомж болон Засгийн газрын 106-р тогтоолыг сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулна.</p> | <p>газар(БОАЖГ), Ойн ангиуд, - Онцгой байдлын байгууллага - Цагдаагийн байгууллага - Мэргэжлийн хяналтын байгууллага - БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад - ЦУОШГ - Ус,цагуур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн - Шуурхай зохицуулалтын жижүүрийн алба</p> |
| <p>4. 1.4. Хавар, намрын хуурайшилтын улиралд 2020 оны 03 дугаар сарын 20-оос 6 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд Цаг уур орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-аас сансрын хиймэл дагуулын мэдээгээр авсан мэдээллийг ой, хээрийн гал, түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг /баяр, амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллах</p> | <p>1.Түймрийн аюултай улирлын туршид түймрийн эрсдэлтэй бүх бүс нутгаар цаг уурын нөхцөлөөр тогтоосон хуурайшилтын зэрэг болон түймрийн голомт, тархалтын зураг боловсруулж холбогдох байгууллагуудад үйлчилнэ.</p> <p>2. Хан-Хэнтий, Богд-уул, Горхи-Тэрэлж, Тужийн нарс, Зэд-Хантай-Бүгээлийн нуруу, Онон-Балж, Дорнод Монгол, Нөмрөг зэрэг Улсын тусгай хамгаалалттай газруудын ой, хээрийн түймрийн орон зайн тархалтын зургийг боловсруулж дээрх газрууд болон ОБЕГ-т хүргүүлнэ.</p> <p>3. ОХУ, БНХАУ-тай хиллэх улсын хилийн бүсэд хил дамнан гарах ой, хээрийн түймрийн мэдээллийг хөрш орнуудтай шуурхай солилцох, зурган болон бусад мэдээг боловсруулж холбогдох байгууллагуудад шуурхай хүргэж ажиллана.</p> | <p>Түймрийн аюултай улирлын туршид</p> |
| <p>5. 1.5. Ой, хээрийн гал, түймрийн эрсдэл өндөртэй хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед ЦУОШГ-ын цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн сумны нэвцгийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих</p> | <p>1.ЦУОШГ-аас "MODIS" хиймэл дагуулын мэдээ, зургийг шуурхай гаргаж холбогдох байгууллагуудад хүргэж үйлчлэх, шаардлагатай тохиолдолд үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг зохион байгуулна.</p> <p>2.Түймрийн эрсдэл бүхий бүс нутагт түймрээс хамгаалах багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p> | <p>Жилийн турш</p> |
| <p>6. 1.6. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16 дах заалтыг хэрэгжүүлэн цаг агаарын болон ой, хээрийн түймрийн цагийн байдлын</p> | <p>1. Ой, хээрийн түймрийн эрсдэл бүхий аймаг, сумдад түймрийн аюултай улирлын туршид эргүүл, харуул гаргах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулна</p> | <p>2, 3-р улирал</p> |

талаарх мэдээллээр холбогдох байгууллага, хүн амыг хангах

2. Улсын тусгай хамгаалалттай газруудын ойг түймрээс хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах, түймрийн эрсдэлийн бүсэд иргэдийн зорчих хөдөлгөөнийг бүртгэх, хяналтын хуудас бэлтгэж, ашиглах, зарим бүс нутгийг тэмдэгжүүлэх, самбар байрлуулах ажлыг зохион байгуулна.

3. Түймрийн цагийн байдлын тухай мэдээллийг холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэх шуурхай зохицуулах жижүүрийг 2020 оны 03 дугаар сарын 20-оос 6 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд яамны дэргэд ажиллуулна.

даргын тамгын газар,
- БОАЖГ, ойн ангиуд, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл

